

БҮРТГЭЛ-ХЯНАЛТЫН КАРТ

Огноо 2022/02/15

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК


Байгууллагын нэр

Зохион байгуулалтын нэгж,ажилтны нэр

Бүртгэсэн		Хаанаас	Баримт бичгийн		
Сар, өдөр <u>02/15</u>	Карт № <u>214</u>	"АЛЕКС КАПИТАЛ УЦА" ХХК	Дугаар	Сар <u>11/14</u>	Хуудасны тоо <u>2</u>

Товч утга ҮНЭТ ЦААСНЫ АНДАГЧ АРИЛЖААНЫ, ХУВИАРЛАЛТЫН
ТӨЛӨӨЛӨГӨД ХҮРМЛЭХ ТУАЙ

Удирдлагын заалт Д.Амармаа, Г.Ташванууза
нэр

Мөвчлэн тэмдэг




“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”

“АПЕКС КАПИТАЛ ҮЦК” ХХК

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимп 5, Аюуд Тауэр, 702 тоот
Утас: 7510-7500,

И-мэйл: investment@apex.mn,

Веб: www.apex.mn

2022 / 02 / 14 # 070 .
он сар өдөр

танай _____ # _____ т

“Үнэт цаасны анхдагч арилжааны”
хуваарилалтын төлөвлөгөө хүргүүлэх
тухай

“Апекс капитал ҮЦК” ХХК нь “Омни актив ТЗК” ХХК-ийн олон нийтэд нээлттэй санал болгож буй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хэлцэлд Андеррайтераар оролцож байна.

“Омни актив ТЗК” ХХК-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн А/12 тоот тушаал, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дугаар тогтоолоор тус тус бүртгэсэн билээ.

“Омни Актив ТЗК” ХХК нь нийт 5,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий баталгаат хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 2022 оны 2 сарын 21- ээс 24-ний өдрийг дуусах хүртэл 10 цаг 00 минутаас 16 цаг 00 минут хооронд Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 10 дугаар зүйлд заасны дагуу “Тогтоосон үнийн арга”-аар явуулах хүсэлтэй байна. Үнэт цаасны анхдагч арилжааны хуваарилалтын төлөвлөгөөг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

1. Нийт 50,000 ширхэг, 5,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасыг нэгж бүрийг 100,000 төгрөгийн нэрлэсэн үнээр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан стратегийн хөрөнгө оруулагчдад болон олон нийтэд санал болгоно.
2. Нийт үнэт цаасны 40 хувь буюу 20,000 ширхэг, 2,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүх үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 3.4-т заасан Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгоно. Андеррайтер нь журмын 3.4-т зааснаас гадна үнэт цаасыг 100,000,000 төгрөгөөс дээш үнийн дүнгээр захиалга өгөн Андеррайтертай “Үнэт цаас захиалан авах гэрээ /Стратегийн хөрөнгө оруулагч/” байгуулсан хөрөнгө оруулагчдыг Стратегийн хөрөнгө оруулагч гэж тогтоон жагсаалт, хуваарилагдах үнэт цаасны тоо ширхэг болон бусад шаардлагатай мэдээллийг Монголын хөрөнгийн биржид хүргүүлнэ.

3. Нийт үнэт цаасны 60 хувь буюу 30,000 ширхэг, 3,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасыг олон нийтэд нээлттэй /Жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад/ санал болгоно. Олон нийтэд санал болгох захиалгаас 100 ширхэг буюу 10,000,000 төгрөг болон түүнээс доош дүн бүхий захиалгыг бүрэн биелүүлэх нөхцөлтэй байна. Худалдан авах захиалгын тоо 100 ширхгээс давсан тохиолдолд нэгж хөрөнгө оруулагчийн 100 ширхгээс дээш давсан үнэт цаасны захиалгыг хувь тэнцүүлэх аргыг ашиглан жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад хуваарилалт хийнэ.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЛХАМДОЛГОР